

ОУВС-гийн Өргөтгөсөн санхүүжилтийн хэрэгсэл (ӨСХ)

Богино хугацаанд шийдэгдэх боломжгүй эдийн засгийн тогтолцооны сул талуудаас үүдэлтэйгээр, төлбөрийн тэнцлийн дунд хугацааны ноцтой хүндрэл тулгарсан тохиолдолд ОУВС Өргөтгөсөн санхүүжилтийн хэрэгслээрээ дамжуулан тохиргоо хийгдэх үйл явцыг дэмжин оролцох боломжтой байдаг. Стэнбай хөтөлбөрийн хүрээнд үзүүлэх дэмжлэгтэй харьцуулахад энэхүү дэмжлэг нь хөтөлбөрийн үргэлжлэх хугацаа урт байдгаараа ялгагдах бөгөөд энэ нь бүтцийн дунд хугацаат шинэчлэлийг хэрэгжүүлэхэд ач тустай байхын зэрэгцээ эргэн төлөгдөх хугацаа илүү урт байдгаар мөн онцлог юм.

Өргөтгөсөн санхүүжилтийн хэрэгсэл ямар зориулалттай вэ?

ӨСХ нь дараах нөхцлийг хангасан улс орнуудад дэмжлэг үзүүлэх зориулалттайгаар боловсруулагдсан: (i) эдийн засгийн бүтцийн гажуудлаас үүдэн төлбөрийн тэнцлийн хүнд асуудалтай тулгарсан; (ii) эдийн засгийн өсөлт удааширсан, төлбөрийн тэнцлийн хүндрэл архаг болсон. ӨСХ нь бүтцийн гажуудлыг уртасгасан хугацаанд засахуйц хэмжээний цар хүрээ, агуулга бүхий бодлогыг багтаасан байж болох цогц хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмждэг.

Тохиргоо үр дүнгээ өгтөл хөтөлбөр хэрэгжих хугацаа болон эргэн төлөлтийн хугацаа урт

Тогтолцооны угшмал гажуудлыг засч залруулах, үр дүнг харахад гол төлөв нилээдгүй хугацаа шаардагддаг тул ӨСХ-ийн хүрээнд хэрэгжих хамтын ажиллагаа болон эргэн төлөлтийн хугацаа ОУВС-гийн бусад арга хэрэгслүүдтэй харьцуулахад урт байдаг.

ӨСХ-ийн дагуу олгогдох санхүүжилт шаардлагатай бол нэгээс дээшгүй жилээр сунгах нөхцөлтэйгээр гол төлөв гурваас дээшгүй жилийн хугацаатайгаар батлагддаг боловч төлбөрийн тэнцэлтэй холбоотой асуудлууд гурваас дээш жил үргэлжлэх, макро эдийн засгийн тогтворжилтыг хангах тохиргоо удаан шинжтэй тул хугацаа шаардах төлөвтэй, мөн эдийн засгийн бүтцийн гүнзгий төдийгүй тогтвортой өөрчлөлтийг хэрэгжүүлэх хүсэл сонирхол, чадамж тус улсад байгаа нь илэрхий байгаа тохиолдолд хугацааны дээд хязгаарыг 4 хүртэлх жилээр тогтоож болно. Эргэн төлөлт хийгдэх хугацаа мөн урт бөгөөд хөрөнгө зарцуулалт хийгдэж эхэлснээс хойш 4.5–10 жилд багтан хийгдэх бөгөөд ижил хэмжээний, хагас жил тутамд хийгдэх 12 төлбөрөөс бүрдэнэ. Харьцуулан жишихэд, Стэнбай хөтөлбөрүүд нь богино хугацаатай байх бөгөөд эргэн төлөлтийн хугацаа нь 3.3–5 жилээр тогтоогддог.

Бүтцийн өөрчлөлтөд тавих анхаарал

ОУВС-гаас зээлжих болсон аливаа улс эдийн засгийн болон бүтцийн алдаа дутагдлуудаа засч залруулах бодлогын амлалтыг авдаг. ӨСХ-ийн хүрээнд ийнхүү авсан амлалтууд нь, үүний дотор тусгайлан заагдсан нөхцлүүд нь институцын болон эдийн засгийн сул талууд руу чиглэгдсэн бүтцийн өөрчлөлтөд онцгой анхаарах шаардлагатай бөгөөд эдийн засгийн тогтворжилтыг хангах бодлогыг дэмжихэд чиглэгдсэн байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийг ОУВС-гийн Захирлуудын зөвлөлөөр тогтмол үнэлж дүгнэх бөгөөд ингэснээр хөтөлбөрийг эдийн засгийн хувьсан өөрчлөгдөх орчин нөхцөлд илүү нийцтэй байлгах боломж нээгддэг. ӨСХ-ийн хүрээнд хийгдэх үнэлгээний давтамжийг тухайн улсын бодлогын зохистой байдал, зээлжих хэрэгцээний онцлогоос хамаараад уян хатан байдлаар тогтоох боломжтой.

ӨСХ-ын дагуу ямар хэмжээний зээлийн санхүүжилтийг авах боломжтой, өртөг нь ямар вэ?

Стэндбай хөтөлбөрийн адилаар ӨСХ-ийн дагуу олгогдох санхүүжилтийн хэмжээ тухайн улсын зээлжих хэрэгцээ, эргэн төлөлтийг хангах чадамж, ОУВС-гийн санхүүжилт авсан өмнөх туршлага зэргээс хамаарна.

Ердийн эрх: ӨСХ-ийн дагуу зээлжих ердийн хязгаар нь хуваарьт эргэн төлөлтийг хассанаар нэг жилд тухайн улсын квотын 145 хувиас, хөтөлбөр хэрэгжих нийт хугацаанд нийлбэр дүнгээр квотын 435 хувиас хэтрэхгүй байхаар тогтоогдоно.

Тусгай эрх: Зээлжих ердийн хязгаараас давсан дүн бүхий зээлийн санхүүжилтийг тохиолдол тус бүрээр хэлэлцсэний үндсэн дээр онцгой нөхцөлд, тусгай эрх эдлэх урьдчилан тодорхойлсон шалгуурууд хангагдаж байгаа тохиолдолд олгож болно.

Мөн түүнчлэн, ӨСХ-ийг ирээдүйд үүсч болзошгүй төлбөрийн тэнцлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, болгоомжлох үндэслэлээр хэрэгжүүлэхгүй байх нь зүйтэй гэж үздэг.

Амлалтын (олголтын) хураамж: ӨСХ-ийн аливаа тохиролцооны дагуу олгогдохоор болсон хөрөнгийн дүнд амлалтын хураамжийг ногдуулан тооцох бөгөөд төлбөрийг 12 сарын хугацаа тус бүрийн эхэнд тухайн хугацаанд ашиглах боломжтой хөрөнгийн дүнгээс тооцож нэхэмжилнэ (квотын 115 хувиас хэтрэхгүй дүнд 0.15 хувиар тооцох бол 115-575 хувьтай тэнцэх дүнд 0.3 хувиар тооцож, 575-аас дээш хувьтай тэнцэх дүнд 0.6 хувиар тооцож ногдуулна). Дээрхи хураамжууд нь тухайн хугацаанд зохих дүнгийн хөрөнгийн ашиглалт хийгдсэн тохиолдолд буцаан олгогдоно. Тиймээс ӨСХ-ийн дагуу олгогдсон хөрөнгийг тухайн улс бүрэн захиран зарцуулж байгаа тохиолдолд амлалтын хураамж бүтнээр буцаан олгогдоно.

Зээлийн хүү: Зээлийн хүү нь ОУВС-гийн зах зээлд суурилсан хүү хэмээн тооцогддог ЗТЭ-ийн хүүтэй шууд уялдах “төлөгдөх үндсэн хүү” дээр суурилсан байна. “Төлөгдөх үндсэн хүү” өнөөдөр ТЗЭ-ийн хүү дээр нэмэх 1.0 хувь хэмжээтэй тэнцүү байна. Томоохон зээлүүдийн хувьд зээлийн үлдэгдлийн дүнгийн квотын 187.5 хувиас хэтрэх хэсэгт хамааруулан нэмэлт 2.0 хувийг тооцдог. 51 сарын дараа зээлийн үлдэгдэл квотын 187.5 хувиас хэтэрсэн хэвээр байгаа тохиолдолд нэмэлт хүү 3.0 хувиар тооцогдох бөгөөд зорилго нь ОУВС-гийн хөрөнгийн эх үүсвэрийг их хэмжээгээр бөгөөд урт хугацаагаар ашиглах явдлыг бууруулахыг зорьж холбоотой.

Үйлчилгээний хураамж: Ашигласан дүн тус бүрт ногдуулан 0.5 хувийн үйлчилгээний шимтгэл авна.